



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 691

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 30,000,000.00 (гучин сая) төгрөгийн балансын үнэ, 3,750,000.00 (гурван сая долоон зуун тавин мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны ... 14 дугаар сарын ... 27 өдрийн  
69.1 дугаар тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН ЯАМАНД  
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Тоёото Лексус LX570,УБЯ 23-00	2013	30,000,000.00	3,750,000.00	26,250,000.00
			30,000,000.00	3,750,000.00	26,250,000.00
	Нийт дүн		(гучин сая)	(гурван сая долоон зуун тавин мянга)	(хорин зургаан сая хоёр зуун тавин мянга)